

Огноо: 2023.05.04

№ 61

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.8 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.10 дахь хэсэг, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 130/А-191 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн банкийг олон нийтэд нээлттэй хувьцаат компани хэлбэрт шилжүүлэх хөтөлбөр”, “Төрийн банк” ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.13.26 дахь заалт, “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хурлын 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн банк” ХК олон нийтэд хувьцаа нэмж гаргахтай холбогдуулан зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах журмыг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын хавсралтаар батлагдсан журмын дагуу зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд танилцуулж, хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д даалгасугай.

3. Журмын хэрэгжилтийн явцыг Төлөөлөн удирдах зөвлөлд улирал тутам танилцуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн банк” ХХК-ийн хэлбэрийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөхтэй холбогдуулан зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд сонгон шалгаруулах түр журмыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар /Б.Болор-Эрдэнэ /-т даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ТЭЛМҮҮН